

蒙古时文选读

第六册

李宪民 编

中国人民
解放军 外国语学院一系第五教研室

一九九七年七月

ГАРЧИГ

27-Р ХИЧЭЭЛ	
ТУЛШ ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАР-----	1
28-Р ХИЧЭЭЛ	
МЭДЭХЭД ИЛҮҮДЭХГҮЙ-----	42
29-Р ХИЧЭЭЛ	
МОНГОЛ ХЭЛ, БИЧГИЙН СУДЛАЛ-----	95
30-Р ХИЧЭЭЛ	
НИСЛЭГИЙН ТОМ ОСОЛ-----	117

27-р ХИЧЭЭЛ
ТУЛШ ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАР

1. НЕФТИЙН ШӨӨЦ УЛСЫН ШУУЦ

/ Цагаанхүүгийн Багмид "чухал хүн шүү" гэж олон хүнээс сонссон. Бодвол хийж бүтээсэн нь чамгүй, тэр чинээгээрээ өгүүлэх юмтай гэсэн үг биз. Тэрээр Зүүнбаянгийн Нефтийн үйлдвэрт цехийн болон ерөнхий инженер, тэрчлэн үйлдвэрийн даргаар ажиллаж байжээ. Мөн эдийн засгийн ухааны дэд доктор цолтой. /

- Та 1960 онд Москвагийн нефть хими-хийн дээд сургуулийг төгсжээ. Тэгээд Зүүнбаянгийн орд руу шууд очсон байх нь ээ? Тэр үед нефть гарч байсан гэдэг байх аа?

- Нефть байгууллагын анхны гурван инженер Аж үйлдвэрийн яамны томилолтоор Зүүнбаянг зүглэсэн хэрэг. Тэр үеэс Цагаан элсэнд хайгуулын өрөмдлөг хийж, 1965 онд дууссан л даа. Хоёр цооногоос нь 1964 онд есөн тонн нефть гарч байсан. Зүүнбаянгаас 1960 онд 28,6, 1965 онд 16,0, харин 1970 онд 4,0 мянган тонн нефть олборлоод, үйлдвэр зогссон. Уг нь үйлдвэр 300-гаад сая төгрөгийн хөрөнгөтэй байлаа.

- Үйлдвэр юунаас болоод тамирдсан хэрэг вэ? Хөдөлгөөд байх арга мухардсан хэрэг үү?

- Нефть өвөл амархан царцдаг учир ашиглалт хүнд байсан. Уг нь халаагуур ашиглаж болно л доо. Мөн цооногийн өгөлтийг сайжруулахын тулд халуун

нэфтийр угаах, тэрчлэн ус шахаж ч үзсэн. Хэрээ Цагаан элсний ордыг ашиглавал 100-гаад цооцог өрөмдөж, 20 гаруй км газарт халаалгатай шугам хоолой тавих тооцоог Зөвлөлтийн мэргэжилтүүд гаргасан. Тэглээ гээд олигтой үр дүнд хүрээгүй. Өөрөөр хэлбэл нэг тонн нефтийн өртөг 700-гаад төгрөгт хүрэх тооцоо гарсан. Тэр үед Оросоос 220 төгрөгөөр авч байлаа шүү дээ. 1968 онд Брежнев дарга ирж, Монголд нефтийн үйлдвэр ажиллах боломжгүй тухай хэлснийг хожим дам сонссон.

-Өнөөдөр нефтьтэй болох нь гэж дээр, доргүй шуугих боллоо. Жишээлбэл, Зүүнбаянгийн Цагаан элсэн дэх орд аль хэр унацтай бол ?

-Цагаан элсний ордын хязгаарыг 2-3 км-ээр өргөтгэж бэлхэд юм. Мөн гүнруүгээ нефтийн давхарга дахин гарах үндэс бий. 1955 онд Зүүнбаянгийн ордоос 55 мянган тонн нефть олборлож байсан. Хажууханд нь 1000-гаад метрийн гүнээс нефть илэрсэн 3-4 тогтоцтой. Энэ бүхнээс жилд 150-200 мянган тонн нефть олзорлох бололцоо бий. Гэхдээ баталгаатай тоо биш шүү.

-Манай улс газрынхаа хөрсөнд 400-гаад сая тонн нефтийн нөөцтэй гэдэг худлаа болж таарах нь ээ?

-Наадах чинь тун бүдүүвтэр тоо л доо. Өөрөөр хэлбэл, хүний царайг нь ажиглаад, зүрх нь мууджээ гэхтэй адил. Юмыг өнгөцхөн дүгнэж болохгүй биз дээ.

-Тэгвэл нийгмийг хий бужигнуулж, мөнгөтэй хүмүүсийн хорхойг хөдөлгөж байгаа хэрэг үү?

Нэфтийн хайгуулд олон компани хошуурч байна. Тийн
өөрсдөө ч ширеэ үмхэх вий.

-Жижигэн бизнесмэн нэг төгрөгнөөс хэдэн мянган
унагахаа тооцож таарна. Гэхдээ нэфтийн хайгуул
өнөө маргаашдаа үр дүнгээ өгөхгүй, аз түршилт
ихтэйг ойлгохсон. Энэ ажил руу тооцоо муутай,
харанхуй хандаж нэфтийнхний нэр хүнд, тэрчлэн
гадаадын хөрөнгө оруулалтад муугаар нөлөөлэх вий
гэж боддог. Нөөц сайн тогтоогүй нөхцөлд тийм
үйлдвэр барж, ийм юм хийнэ гэх нь утгачүй.
Жишээлбэл, Баян-Ойл компани жилд хэдий хэмжээний
нэфть гаргах баталгаа хэрэгтэй. Дараа нь үйлдвэр
ажиллах, бид нэфтийг нь худалдаж авах эсэхийг
шийдэх ёстой. Гэхдээ манайд Араб, Кувейтийн
нэфтийн ордууд шиг том эх булаг байхгүй. Дотоодын
хэрэгцээгээ хангаж, багахан хэсгийг экспортлох
боломж бий.

-Нэфтийн "амьд" нөөц мэдэгдэхгүй байхад улсын
нууцад яагаад багтаадаг хэрэг вэ?

-Газрын хөрсөн дэх нэфтийг улсын нөөцөд
буруулдаггүй шүү дээ. Тэгээд ч мэдэх хүн байхгүй.
Харин олборлюод хадгалж байгаа нэфть бол улсын
нөөц төдийгүй нууц. Хаана, хэдий хэмжээний нэфтийн
бүтээгдэхүүн нөөцөнд байгааг удирдах тушаалын хоёр
гурван хүн мэддэг. Нөөцөөс Засгийн газрын
тогтоолын дагуу улсын батлан хамгаалах, эдийн
засгийн аюулгүй байдал, тэрчлэн цаг уурын гэнэтийн
бэрхшээлтэй үед хэрэглэдэг. Нэфтыгүй орон эс

хөнгийн мэргүүрэний нөөцтэй байх, олон улсын нийтлэг журам бий. Тухайлбал, Срос нефтийн өдлийн боллиоо гэхэд манай Савнд дор хаяж турван сарын турш "амна аргалах" нөөц байх нь зөв биш үү.

-Ер нь гаафын тосыг хүмүүс нэлээд сонжих болоо чадаа. Навд зах нь, газрын тосны хөтөлбөрийн дэд хувьцааны төлөвлөгөө боллиоо гэдэг?

-Хөтөлбөрийг удаан хугацаанд Санхүүжүүлэх эх үүсвэрэйг бодволцож таргамаар юм. Зөвхөн Засгийн газрын эжилтэх хугацааны хөтөлбөр байж болохгүй л дээ. Уг нь дийлэнх заалт нь нефтийн хайгуулын тухай юм билээ. Гэтэл халуун амьсгалыг нь мэдээрч суугаа хүмүүст өгөхгүй нууцалдаг нь ямар учиртайг бүү мэд... Тэрчлэн газрын тосны хуульд зарчмын хэдэн өөрчлөлт оруулахсан. Үүн түрүүнд нефтийн хайгуул, олборлолт, боловсруулалт, түгээлтийг зохицуулахад төрийн оролцоо, аж ахуйн нэгжийн хүлээх хариуцлагыг тодорхой заах цаг болсон. Мөн нефтийн үндэсний компани байгуулж, гадаадын компаниудтай өрсөлдөх түвшинд хүргэхэд тодорхой нөлөөлмээр байна.

-Саяхан нефтийн Үндэсний нэгдэл байгуулагдсан биш үү. Тэдэнд гадаадын хүчтэй компани нэгдэлтэй өрсөлдөх боломж бий болов уу?

-Дүрэм журамтай нь сайн танилцаагүй. Дотоодын хөрөнгө оруулалтаа зохицуулж, хүчээ нэгтгэн, нэгэн зүгт зүтгэж чадвал л юм. Гэтэл манайхан гадаадад очиж, хоорондоо өрсөлддөг зуршилтай. Үүнээс салах

цаг болсон. Ер нь нефтийн чиглэлийн компанийн албан хүчээр нэгтгэн, төрийн ивээлд байлгах хэрэг биш. Хөрөнгө нь эргээд төлөгдөх, өөрөөр хэлбэл ашиг өгөх нөхцөлтэйгээр нэгтгэх нь чухал.

-Манай улс 1994 онд 400-гаад мянган тонн бензин, дизелийн болон онгоцны түлш, мазутыг хэрэглэсэн галуу. Цаашид аль хэр хэлбэлзэх бол ?

-Өсвөлгэй байлаа гэхэд 2000 оны үед 500 мянган тоннд хүрэх болов уу. Ямар ч гэсэн дэлхийн зах зээлээс нефтиэ авч, улсынхаа хэрэгцээг хангаж байна. Тухайлбал, 1994 онд хувийн компаниуд 30 гаруй мянган тонн нефтийн бүтээгдэхүүнийг гаднгас оруулж ирсэн. Манай улс түүшний чиглэлээр боловсруулалт хийвэл мазут жаахан илүү гарна. Үүнийг жижиг станцад өгөх юмуу, гадаадад худалдах болох юм. Бусад бүтээгдэхүүнийг бүрэн хэрэглэх бололцоотой.

-Бусдын өмнө сав тосож, суухгүй, нефть боловсруулах үйлдвэр байгуулах цаг ойрхон бололтой. Үүнийг ганц концерн үүрч дийлэх үү? Ер нь төрийн оролцоо юу байж болох вэ?

-Жилд олборлох нефтийн нөөцийг тогтоосны дараа үйлдвэр байгуулахаа бодох учиртай. Одоо хайгуул хийж байгаа гадаадын компаниуд жижиг үйлдвэр оруулж ирэх болов уу. Энэ нь зөвхөн анхны нэрлэгээр бензин, зуны дизелийн түлш, маазут гаргана. Харин бензиний чанар нь манай стандартад тохиорхгүй учир нэмэлт аргууд хэрэглэж таарна. Ер

Нь Монгол Улсын нефтийн бүтээгдэхүүнээр түүштэй хамгаалж жилд нэг сая тонн нефть боловсруулах үйлдвэр шаардлагатай. Ингэснээр л олон улсын стандартад тэнцэх бензин гаргана. Мен бага оврын үйлчилгээний тухай нэлээд яригдаг. Энэ нь бүтээгдэхүүний чанарт муу нөлөөтэй. Харин гаргасан биензинийг нь дахин боловсруулж чанаржуулдаг үйлдвэр байж болно. Ер нь манай 500-600 мянган тонн нефть боловсруулдаг хоёр үйлдвэртэй байхад хэрэгцээгээ хангана. Цаашид бодож нэг зүйл гэвэл, этилтэй бензин хэрэглэхгүй байх нь зөв. Ядаж л байгаль орчноо хамгаалж үлдэнэ.

-Манай олборлох нефтийн бүтээгдэхүүн этилтэй байх уу?

-Бензиний октаны тоо өсөх тусам чанар нь сайжирдаг. Зүүнбаянгийн бинзиний октаны тоо 60 орчим, одоо хэрэглэж байгаа бинзинийх 76 юм. Энэ тоог өслэхийн тулд этилийн шингэнээс өөр бүтээгдэхүүнийг хэрэглэх нь зөв дөө.

-Та "НИК-ОЙЛ" компани байгуулсан гэлүү?

-Бид бусдын юмыг худалдаж ашиг олоод сууна гэвэл эндүүрэл болох биз. Цаашид боломжийн хөрөнгийг нефтийн хайгуулд хаях нь хожоотой. Энэ үүднээс "Нефть импорт" концернийн дэргэд компани Байгуулах боллоо. Захирлаар нь намайг сонгосон. Шаваа тавиад 2-3 хонож байгаа учир тийм зүйлийг ингээд хийчихнэ гэх арга алга. Ер нь тодорхой талбайд нефтийн хайгуул хийх, боловсруулах үйлдвэр

байм уулзахад оролцох зорилготой.

-Боли, бэнчин овоо биз?

-Зөвхэн эхний гурван жилд нэг талбайд хайгуул хийхэд 8 сая доллар үрэх болов уу. Цаашил боловсруулах үйлдвэр байгуулах учир гадаадын баниглаасынголттай зээл авах юмуу томоохон компаниудтай хамтарч хөдөлнө. Мөн дотоодын хөрөнгө оруулалтыг нефть импорт концерн зохих хэмжээгээр гаргах бололцootой. Ямар ч гэсэн халаасандаа бага зэрэг мэнгэтэй, боловсон хүчин сайн, үйлдвэрлэлийн зохих бааттай гэсэн үг.

-Үүгээрээ хайгуулын бусад компаниас давуу гэж ойлгож болох нь ээ! Хаана талбай авав?

-Зарласан газраас хоёр талбай авах өргөдлөө "Газрын тос" товчоонд өгсөн. Засгийн газарт оруулж шийдэх байлгүй. Хэддүгээр талбай гэж хэлмээргүй байна.

Ж. АЛТАНГЭРЭЛ

2. Торхонд маань 15000 баррель газрын тос бий

/ Ерөнхий сайд М. Энхсайхан дипломатуудтай уулзахдаа Монгол Улс газрын тос олборлож, экспортолсон тухай мэдээлэв. АНУ-ын "Нескор Энержи" компанийн монгол дахь байнгын төлөөлөгч бөгөөд "Баян Ойл" компанийн удирдах захирал Роберт Фридлайнтай манай сурвалжлагч ярилцжээ. /

-Дээр хувь зохиолоор та монголын газрын төсны сийн дээр шөөдөр маргааштай холбогдсон юм бэ?

-Би АНУ-ын гадаад харилцаанд 30 жил дипломат алба хийсан. Сүүлийн хоёр жилд АНУ-аас Монголд здийн засгийн тусламж үзүүлэх агентлагийн даргаар Улаанбаатарт ажиллав. Намайг АНУ-ын "Нескор Энержи" компани урьж байнгын төлөөлөгчөөр монголд ажиллаач гэж хүссэн юм. Би дуртай зөвшөөрсөн.

"Нескор Энержи" бол нефтийн бүтээгдэхүүн эрж хайх, олж илрүүлэх, олборлох үйлдвэрлэх талаар нээд гарсан манай улсын том компани. Монголыг би муугүй мэднэ. Монголд ардчилал хөгжих ажиллахад таатай нөхцөл бүрдэж байв. Монголын газар шорооноос нефтийн бүтээгдэхүүн оргилуун дарс шиг бургилахыг нүдээр үзэхийг хүссэн юм.

-Хэдэн оноос танайх Монголд төслөө хэрэгжүүлж эхэлсэн ба ?

-АНУ-ын "Нескор Энержи" компани Монголын Засгийн газартай хамтарч 1993 онд газрын тос олборлох төсөл боловсруулан хэрэгжүүлж эхэлсэн. Тавь тавин хувиар хөрөнгө оруулалт хийж, эцсийн үр ашиг орлогыг нь мөн тавин хувиар эзэмшихээр гэрээ байгуулж гарын үсэг зурсан.

-Монголд газрын тос олборлох үйл явц чухам ямар шатандга явж байна вэ?

-Төслийг монголд хэрэгжүүлэх ажлыг гүйцэтгэх зорилгоор "Баян-Ойл" компани байгуулсан. Хоёр талбайд өрөмдлөг хийсэн. Нэлээд олон цооногийг

жин ажиллуулав. Газрын тос хадгалах нийтийн зорьтой болсон.

- "Саалия балдажаэр саваа зэх" гэж монголчууд ярьдаг. Газрын тосны том торх маань арай хоосонгүй бий дээ.

-Тийм ээ. Газрын тос хадгалах энэ торхонд монголын газар шорооны гүнээс оргилуулж авсан 13000 баррель (нэг баррель нь 159 литртэй тэнцэнэ) газрын тос хадгалагдаж байна. Монгол Улс анх удаа гадаадад 100 баррель газрын тос экспортлон гаргав. Энэ зүн үйлдвэрлэлийн туршилтыг амжилттай хийлээ. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа жигдрээд ирэхийн цагт ноён олборлох боломжтой болохыг нотолсон.

-Ер нь Монгол Улсын газрын тос дундарч шавхрах болов уу?

-Хэдэн арван жилдээ лав дундражгүй гэж итгэлтэй хэлж болно.

-Манай газрын тос дэлхийн өөр өнцөг булан нутаг уснаас олгойддог газрын тосноос чанараар ямар вэ?

-Газрын тос инэ бүр байдаг. Ер нь газрын муу тос гэж бараг байдаггүй. Ямар зорилгоор ашиглах вэ гэдгээсээ ихээхэн шалтгаална.

Танай газрын тос бол хүнд тос. Шатаж тослох шингэн материал үйлдвэрлэхэд илүү зохимжтой. А-76 болон бусад маркийн бензин шатахуун гаргаж авъя гэвэл дахин боловсруулах үйлдвэр байгуулах, нэмэлт төхөөрөмж тавих шаардлагатай.

-Өнгөрсөн хэдэн жилд газрын тос олборлож үр

дүнд хүрэхэд хэр зэрэг мөнгө хөрөнгө зарцуулсан бол?

-Монголын Засгийн газар "Нескор Энержи" компани хамтраад газрын тосыг олборлоход өнөөдрийн байдлаар 55 сая ам долларын хөрөнгө оруулалт хийсний дийлэнх хувийг нь "Нескор Энержи" компаниас оруулжээ.

-Монголын радиогоор газрын тосны мэдэгдэл хийхийг сонссон. Газрын тос олборлоход гацаа түгжрэл баагүй байгаа юмаа даа.

-Тиймээ. Төслийг хэрэгжүүлэх явцад Монголын Засгийн газарт санхүү мөнгөний гачаал тохиолдсон. Гэрээ хэлэлцээрт заасан хувь хэмжээгээр хөрөнгө оруулалтадаа цаг тухайд нь хийж чадсангүй. Иймээс газрын тос олборлох, ажлын эрч суларч, сунжран гацааж түгжрэх бэрхшээл тохиолдоод байна.

-Гацаанаас гарах арга, замыг хэрхэн эрж хайж байна вэ?

-"Нескор Энержи" компани Монголд газрын тос олборлох энэхүү төслийг бизнесийн хүрээнд ч Монголын талд ч үр ашигтай гэж үзэж байна. Тиймээс ч ажлаа зогсоохгүй үүднээс Монголын Засгийн газрын нэрийн өмнөөс нэлээд хэмжээний хөрөнгө оруулалтыг хийж байлаа. Энэ нь танай Засгийн газрын сэтгэлийг зовоож эмзэглүүлэх болсон. Яагаад гэвэл өр төлбөр зузаарч байлаа. Бид танай Засгийн газартай байгуулсан гэрээгээ шинэчилсэн. Өр барагдуулах үйлдвэрлэлээ сэргээх аргыг зүйл бүрээр эрж хайж

Зайна. "Нэскэр Энержи" компани өр ширгүй төлбөрийн харьцаангуй сайн чадавхитай болохыг хэлмээр байна. Гачаанаас гарна гэж найдаж явна.

-Монголмууд газрын тосыг эртнээс хүсч хүлээсэн. Өдийд газрын тосоо бялхуулан өөрийн нефтийн бүтээгдэхүүнтэй болж, бинзин шатахуун, тослох материалын үнэ ханш хямдарч, амь зуулга дээрдэнэ гэж найдаж байсан...

-Ийм дэврүүн сэтгэл зүйн уур амьсгал Шотландцад ч тохиолдож байсан. Шотландчууд газрын тос олборлож эхэлснээс хойш хэдхэн сарын дотор л иргэд нь чинээлэг улс гүрэн л баян болчих юм шиг санаж байсан. Гэвч газрын тос олборлох, үйлдвэрлэх борлуулах ашиг олох гэдэг нь говьд өрөмдмөл худаг гаргаж мал сургээ ханатал умдаалахтай адилгүй. Олон он жилийн хойно үр ашиг нь мэдрэгдэнэ. Эхлээд гарзаа олзоор нехнэ. Газрын тосны эцсийн бүтээгдэхүүнийг ихээхэн хэмжээгээр үйлдвэрлэхэд далайн чинээ гарз гардаг. Иймд ганц хоёр жилд зарлагaa нехөхөд амаргүй. Монгол орон далай тэнгэсэн зам тээврээс хол хөндий оршдог. Орос нефтийн бүтээгдэхүүнээр баян орон. Хятад харьцаангуй хараа хяналттай гүрэн. Гэвч газрын тосны үр ашгийг үзэх тунчиг холгүй.

-Та газрын тосны маргаашийг хэрхэн төсөөлж байна вэ?

-Сайнаар. Шинэ онд газрын түүхий тосны олборлолтоос орлого олно. Гэвч цэвэр ашиг олтол

Хсөр түргэн хүнийн сайхан байх болов уу. Монголын Засгийн газар газрын тосны олборолтод онцгой анхаарал тавьж байгаа. Стратегийн ач холбогдол ч өгч байна. Хэрэв танай Засгийн газар өрөө барагдуулж, хөрөнгө оруулалтаа хийж чадахгүйд хүрвэл "Нескор Энержи" компани 100 хувийн хөрөнгө оруулалт хийх санаачилга гаргасан. Энэ Санал баталгаажвал манай компани 1997 онд 8 сая ам. долларын хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөж байна. Менгэ санхүүгийн гачаал гацаанаас ийн гарчихвал ирах хавраас газрын тосны үйлдвэрлэл жигдэрч, аль аль талдаа ашигтай ажиллана гэдэгт итгэл төгс байна.

-Монголд ажиллах нөхцөл ямар вэ? Монголчуудтай ажиллаж түншлэхэд хэцүү юу?

-Танай оронд ажиллахад таатай байна. Манай "Баян Ойл" компанийд 170 шахам хүмүүс ажилладаг. Одоогоор орон тоог жаахан цомхотгосон тал буй. Тэд мэргэжлийн ур чадвар, ажиллах арга барилаар гаргууд сайн. Найзлаж түншлэхэд ч хэцүү биш.

-Газрын тосны үйлдвэрлэл жигдрээд ирвэл ажлын шинэ байр нэмэгдэх болов уу?

-200 гаруй монголчууд ажиллах байх. Манайд ажил хүнд цалин пүнлүү өндөр. Гэр бүл үр хүүхдүүдийг нь оролцуулбал 1000 гаруй хүнийг элбэг тэжээх болно.

3. Ерөнхийлөгч газрын тосны

ДЭВЭРЭР ДОСЛОТ МАЛААВ

Сүүлийн түүдэд хийсэн судалгаараар чанай срилчнүүтгэг газрын тосны гурван сав газар тогтоогдсон. Үүнээс Тамсаг, Зүүнбаянгийн сав газарт хайгуулын ажил эхлээд байгаа билээ. Монголд болсон гадаадын хөрөнгө оруулагчдын чуулга уулзалтын ирсэн төлөөлгөгчийн сүүлч буцаж амжаагүй байхад буюу энэ сарын 6-ны өдрийн 16, 35 цагт Дорнод Монголын тал уүцээ нээлээ. Тамсагийн сав газрын XIX талбайн гурав дахь цооногоос газрын тос оргилон гарав. Энэ нь чуулга уулзалтын дараа болсон томоохон үйл явдал.

... Тамсагт гарсан газрын тосыг үзэхээр монгол Улсын Ерөнхийлөгч П. Очирбат, ХААУ-ийн сайд Л. Нямсамбуу, Батлан хамгаалахын сайд Д. Дорлигжав, Газрын тосны хэрэг эрхлэх газрын дарга Г. Энхболд нар уржигдар 13 цагт Улаанбаатараас мордлоос. Таван цаг нисч, 18 цагийн орчимд зорьсон газартаа хүрэв. Зээрийн сургээс өөр нүдэнд торох бараагүй тэгш ногоон талд арван хоёр давхар барилгын дайтай өндөр өрмийн цамхаг сундэрлэн босчээ. Газрын гүнээс оргилсан тосыг хоолойгоор дамжуулж, тусгайлсан байгуулсан даланд хуримтлууж байв. Цооногоос гаргасан нөгөөх хоолойгоор байгалийн хий гарах ажээ. Энэ цооногоос эхлээд өдөрт 1500 баррель газрын тос урсан гарсан гэнэ. 16 цаг олборлолтын туршилт хийхэд өдөрт 687 баррель газрын тос гарч, гарц тогтмолжээ. Иймд АНУ-аас

ачуулсан олборлолтын тоног, төхөөрөмжийг дээрээ туршилтын ажлаа түр зогсоогоод байгаа юм байна.

Ажилчдын Ерөнхийлөгчид газрын тоскоо оргилуулж, байгалийн хийг асааж үзүүлэв. Ерөнхийлөгч П. Очирбат "Би энэ газрын тосны дээжээс дээлээ мялаая" гэхэд бусад нь "Нэлд нь шурчих байх" хэмээн хоригчонгуй байлаа. Ерөнхийлөгч өөрийн санаснаар болж даланд тунасан тосонд гарaa дүрэн, магнайдаа хүргэв. Дараа нь цугларсан хүмүүст хандан:

-Би 1994 оны намар Зүүн-Баянгийн Цагаан элсэнд анхны өрөм зооход очиж "Өрөмдлөгө амжилттай болж, цосногоос газрын тос оргилуун дарс шиг оргилж байгаасай" гэж өрөөсөн. Монголын ард түмний олон жил хүсч, мөрөөдсөн зүйл биелж байна. Ийм учраас энэ тосны дээжээс ард түмнээ төлөөлөөд дээлээ мялаая гэв. Газрын тосны дээжээс хоёр гарaa дүрэн, шур, оюун товруу шигтгаэтай суран бус бусалсан, ухаа шаргал даавуу дээлийнхээ энгэр биед хүргэн мялаав. "Бид газрын дор байсан тосыг газрын дээр хамтын хүчээр гаргалаа. Эх орныхо газрын тосны их баялгийг ард түмэндээ нээгээд өгчих юмсан гэж хичээн зүтгэж явсан хэрэг минь бүтлээ" гэж сэтгэл догдлон хэлж байлаа.

Газрын тосны хэрэг эрхлэх газрын дарга Г. Энхболд:

-Газрын тос олборлох ажил 1986 оноос эхэлсэн. АНУ-ийн "СОКО" компани өнөөдрийн амжилтад хүртлээ

17 сая ам. доллар зарцууллаа. Газрын тос сссртэй эхийн паралтайгээр ийнхүү оргилж гарах тохиолдол маш ховор байдаг. Энэ бол монголд газрын тос оргилон гарсан анхны тохиолдол гэв. Бид 3500 метрт өрөмдлөг хийхээр төлөвлөж байсан. Гэтэл 2398 метр өрөмдээд газрын тос гарсан. Дараагийн талбайн дөрөвдөх цооногийг эндээс 700 метрийн зйтгэлийг газар өрөмдөнө гэж Монголын инженер залуу ярьж байв.

Газрын тосны дээжийг үзсэний дараа Ерэнхийлэгч, дагалдаа нваа сайд, дарга нар, газрын тосны мэргажилтнүүдийн хамт өрмийн цамхагийн дэргэд дурсгалын зураг татуулав. Тэнд ажиллаа бүр "Соко" компанийн Монгол дахь төлөөлөгч Боб Вошен Ерэнхийлэгчид "Тамсагийн баг" гэсэн бичиг бүхий саравчтай малгай дурсгалаа.

Брэхнийлэгчийн суусан нисдэг тэрэг Тамсагийн XIX талбайгаас хээрхөд зөвлөн бороо живээрч үдэв. Цагийн дараа Дорнод аймгийн нисэх онгоцны буудалд ирж нисдэг тэргээ цэнэглээд Улаанбаатар руу хөдөллөө. Тэндээс өртөө газар холдоход уудам талд хэдэн млнгаараа сурэглэсэн цагаан зээр үзэгдэв. Хамт явсан АНУ-ын гурван мэргажилтэн нисдэг тэрэгийн цонхоор заацаан, гайхан биширч явлаа.

Ийнхүү Тамсагийн тосны дээжийг их л бэлгэшээн Улаанбаатарт авчирлаа. Газрын тос гарна гарахгүй хэмээн ярыцгааж суусан монголчууд ямартаа ч газарын тос олборлох боллоо. Харин одоо газрын тос хэдий хэмжээгээр олборлох вэ гэдгийг ярих цаг